# Борлуулалт засах, буцаах, устгах болон борлуулалтын тайлангууд

Энэ сэдэв нь нэгэнт хийсэн борлуулалтыг хэрхэн засах, буцаах, устгах болон борлуулалтын тайлан мэдээнүүд хэрхэн харах тухай зааврыг агуулсан.

Харин хэрхэн анх шинээр борлуулалт хийх тухай зааврыг гарын авлагын "Борлуулалт хийх" сэдвээс уншиж болно.

Энд бид дараах үйлдлүүдийг тайлбарлана:

_	Борлуулалт хайх	2
_	Эм бараагаар борлуулалт хайх	2
_	Баримт нөхөж хэвлэх	3
_	Борлуулалт засах	4
_	Борлуулалт буцаах буюу буцаалт хийх	7
_	Борлуулалт устгах	8
_	Устгасан борлуулалт сэргээх	8
_	Борлуулалтын өөрчлөлтийн түүх харах	9
_	Борлуулалт хэн хийснийг харах, борлуулалт хийсэн ажилтан/хэрэглэгчээр шүүх	11
_	Өдрийн нэгтгэл хэвлэх	12
_	Борлуулалтыг Сараар нэгтгэж харах	14

### "ЦЭС -> Борлуулалт" модульруу орно:



# Борлуулалт хайх

_		1 77		, ,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,		1 33	•	• •					
	БОРЛУУЛАЛТ										— (	, c	×
ſ	Ажлын хэсэг	Бараагаар хайх, За	дгай Нэ <mark>гтгэл: Ху</mark>	гацаагаар Нэгтгэ.	л: Харилцагчаа	р Нэгтгэл: Бараа	гаар Банк ПОС г	гүйлгээ Энгий	ін жорын тайла	4			
Ļ	+ Clace	💢 Шүүлти	<b>ійн огноо</b> 2024-08	3-21 🔻 2024-08	-21 🔻 Эми	йн сан 🔹 🔻	🍸 Шуүх 🛛 🍸	[Харилцагч х	. 🔻	💶 🔒 Өдр	ийн нэгтгэл	8	Ð
		1		/		Ди			Тө	лөлтийн задарг	аа		
	Баримтын дугаар	Огноо	2 Хаанаас	Харилцагч	<b>3</b> - Тоо.ш	<b>4</b> Төлөх дүн	Нийт төлсөн	Бэлнээр	Картаар	Шилжүүлгээр	Зээлээр	QPa	ay
l	2												
ľ	000-334532	2024-08-21 16:59	Эмийн сан		1	20,000.00	20,000.00	20,000.00	0.00	0.00	0.00		
	000-334531	2024-08-21 16:56	Эмийн сан	-5	30	24,900.00	24,900.00	24,900.00	0.00	0.00	0.00		
	000-334530	2024-08-21 16:54	Эмийн сан		39	68,000.00	68,000.00	68,000.00	0.00	0.00	0.00		
	000-334528	2024-08-21 16:37	Эмийн сан		1	6,000.00	6,000.00	6,000.00	0.00	0.00	0.00		

"ЦЭС -> Борлуулалт" модульруу орно. Дараах "Борлуулалт" цонх нээгдэнэ.

- "Ажлын хэсэг" хуудас шууд нээгдсэн байна. Энд борлуулалт баримтаараа жагсаж гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, нэг борлуулалт нэг мөр байна. Харин борлуулалт доторхи бараа нь доор нь харагдаж байгаа. Хэрэв хайж буй борлуулалтын дүн, огноо эвсэл дугаарыг мэдэхгүй бол эндээс олоход хэцүү бөгөөд "Бараагаар хайх, Задгай" хуудаснаас хайх нь зөв. Энэ тухай дараагийн гарчгаас хараарай. Нэгэнт борлуулалтаа олсон бол үргэлжлүүлэн бусад ихэнх үйлдлүүд болох засах, буцаах, устгах үйлдлүүдийг энд буюу "Ажлын хэсэг" дотроо хийнэ.
- 2) "Шүүлтийн огноо" талбар хэднээс хэдний хоорондох борлуулалт хармаар байгаагаа оруулна.
- 3) Хэрэв олон салбартай бол аль салбарын борлуулалт харахаа энд сонгоно.
- 4) "Шүүх" товчыг дарж борлуулалтуудаа дуудаж гаргаж ирнэ.
- 5) Борлуулалтын хүснэгт дээр дахин шүүлт хийнэ. Үүний тулд хүснэгтийн дээр байгаа хайлтын мөр буюу хоосон мөр дээр, хайхыг хүссэн баганыхаа харгалзах хоосон нүдэнд хайх утгаа бичнэ. Хүснэгт дээр хэрхэн хайх тухай дэлгэрэнгүйг гарын авлагын "Хүснэгтийг бүрэн ашиглаж сурах" сэдвээс уншиж болно.

# Эм бараагаар борлуулалт хайх

_													
ſ	БОРЛУУЛАЛТ			1								- 0	×
	Ажлын хэсэг	Бараагаар хай:	х, Задгай Нэгтгэл	: Хугацаагаар Нз	еттгэл: Харилцагчаар	о Нэгтгэл: Ба	раагаар	Банк ПОС гүйлгээ	Энгийн жор	ын тайлан			
	Огнооны шүүл	2024-08-14	▼ 2024-08-21	<ul> <li>Эмийн сан</li> </ul>	- 🍸 Шүүх	(	~2				X	Excel -pyy r	аргах
	Бар	имтын толгой	мэдээлэл		Бараа	ны мэдээлэл	2				Үнэ, тоо хэмж	39	
	Баримт №	Хаанаас	Гүйлгээний огноо	Ангилал	Баркод	Дотоод код	Ба	∘ рааны нэр	Too.x	Нэгжийн үнэ	Хямдрал	Зарсан үнэ	Нийт
	٩						шприц 5г	p					<b>^</b>
	000-334527	Эмийн сан	2024-08-21 16:36	Бусад	4870144262314	4870144262	Шприц 5г	p	21	400	0	400	
	000-334408	Эмийн сан	2024-08-21 09:50	Бусад	4870144262314	4870144262	Шприц 5г	p 3	3	400	0	400	
	000-334362	Эмийн сан	2024-08-20 14:59	Бусад	4870144262314	4870144262	Шприц 5г	p	5	400	0	400	

- 1) "Бараагаар хайх, Задгай" хуудасруу орно. Энд борлуулалт бараагаараа задгай гарч ирдэг. Жишээ нь нэг бараанд гурван нэр төрлийн бараа байгаа бол энд гурвуулаа жагсаж гарч ирнэ. Өмнөх Ажлын хэсэг хүснэгтэд тэд нэгдэж нэг борлуулалт гэдэг утгаар нэг мөрөөр харагддаг бол энд гурван мөрөөр, бараа бүрээр жагсаж харагдана. Тиймээс эндээс нэг барааг хэзээ хэзээ, ямар ямар тоо хэмжээ болон үнээр зарсныг харахад тохиромжтой. Хэрэв аль нэг эм барааны тоо хэмжээ эсвэл зарах үнийг буруу оруулж зарсан тохиолдол байгаа эсэхийг хайж байгаа бол энэ хүснэгтийг ашиглах нь тохиромжтой.
- Багцаагаар хэдний борлуулалт хайж байгаа эсвэл хэднээс хэдний хоорондох борлуулалт хэрэгтэй байгаагаа Шүүлтийн огноо дээр оруулаад, нэгээс олон салбартай бол салбараа сонгоод Шүүх товч дарж борлуулалтуудаа гаргаж ирнэ.

- 3) Гарч ирсэн борлуулалтууд дотроос дахин барааны нэрээр хүснэгт дотроос шүүлт хийнэ. Үүний тулд хүснэгтийн хайлтын мөр буюу эхний хоосон мөрийн барааны нэр баганад харгалзах хоосон нүд дээр барааны нэрээ бичиж шүүнэ. Хүснэгт дээр хэрхэн хайх тухай дэлгэрэнгүйг гарын авлагын "Хүснэгтийг бүрэн ашиглаж сурах" сэдвээс уншиж болно.
- 4) Хэрэв хайж буй борлуулалтаа засах, буцаах, баримт нөхөж хэвлэх зэрэг үйлдэл хийх бол "Ажлын хэсэг" -рүү орж хийнэ. Үүний тулд энэ хүснэгтээс борлуулалтынхаа "Баримт №" болон "Гүйлгээний огноо" талбарын (хүснэгтийн хамгийн урд байгаа) утгуудыг харж авах эсвэл хуулж аваад (дээр нь хулганаар дарж сонгоод гараас Ctrl+C дарж хуулна) Ажлын хэсэгрүү орж эдгээр утгуудаараа тэр борлуулалтаа хайж гаргаж ирээд (Ажлын хэсгээс борлуулалт хайх тухай өмнөх гарчгуудаас хараарай) дараагийн үйлдлүүдийг хийнэ.

## Баримт нөхөж хэвлэх

"ЦЭС ->	Борлуулалт"	модульруу	орж "Борл	иуулалт"	цонхыг нээнэ.
				.,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,	цоплон нооно.

Б	ОРЛУУЛАЛТ	-											
1	Ажлын хэсэг	Бараагаар хайх, За	дгай Нэ <mark>гтгэл: Ху</mark> г	ацаагаар Нэгтгэ	эл: Харилцагчаар	р Нэгтгэл: Барааг	гаар Ба	анк ПОС г	үйлгээ	Энгийн х	корын тайла	н	
	Sacax	🖌 💥 Шүүлти	<b>йн огноо</b> 2024-08	3-21 🔻 2024-08	3-21 ▼ Эми	йн сан 🔻 💙	ү Шүүх	<b>Y</b>	[Харилца	агч х	•	X	🚔 Өдриі
		$\geq_1$			•	Дү	н				Te	лөлтий	ін задаргаа
	Баримтын дугаар	Огноо	Хаанаас	Харилцагч	2 Тоо.ш	Төлөх дүн	Нийт те	элсөн	Бэлнэ	эр	Картаар	Шилж	үүлгээр
٩													
	000-334532	2024-08-21 16:59	Эмийн сан		1	20,000.00	20	,000.00	20,0	00.00	0.00		0.00
×	000-334531	2024-08-21 16:56	Эмийн сан		30	24,900.00	<b>R</b> :	3acax			-		0.00
	000-334530	2024-08-21 16:54	Эмийн сан		39	68,000.00	*	Устгах			_3		0.00
	000-334528	2024-08-21 16:37	Эмийн сан		1	6,000.00	-	_	_			-	0,00
	000-334527	2024-08-21 16:36	Эмийн сан		155	112,850.00		Баримтэ	кэвлэх			_	0.00
	000-334519	2024-08-21 16:13	Эмийн сан		120	48,000.00	-	Нэхэмж	лэх хэвлэ	9X: A4			0.00
	000-334518	2024-08-21 16:12	Эмийн сан		120	478,500.00	-	Нэхэмж	лэх хэвлэ	эх: А5			0.00
	122 w				4,299	4,428,790.00		Баримтэ	кэвлэх: Ц	аасны х	эмжээ сонг	х	0.00

- 1) Ажлын хэсэг хуудас дотроос баримт нөхөж хэвлэнэ.
- Хэвлэх гэж буй баримтаа хайж гаргаж ирнэ. Үүний тулд Шүүлтийн огноо -д хэвлэх борлуулалтын огноог оруулаад салбараа сонгоод Шүүх товчийг дарж тэр өдрийн борлуулалтуудыг гаргаж ирж байгаад хүснэгтээсээ хайна. Хайх тухай өмнөх гарчигуудаас дэлгэрэнгүй хараарай.
- 3) Хүснэгт дээрээс хэвлэх борлуулалт дээрээ хулганы баруун товчийг дарна. Гарч ирсэн коммандуудаас "Баримт хэвлэх" коммандыг сонгоно.
  - а. Хэрэв танай програм ИБаримттай холбогдсон бол энэ хэвлэх үйлдлээр шууд ИБаримт үүсч сугалааны дугаар, QR код гарч ирнэ. Хэрэв өмнө нь уг борлуулалтаас ИБаримт гаргаж байсан бол дахин хэвлэх үед дахин ибаримт үүсэхгүй бөгөөд зөвхөн өмнө үүссэн баримтын ДДТД (Дахин давтагдашгүй төлбөрийн дугаар) гарч ирнэ.
  - b. Хэвлэх баримтын цаасны хэмжээ нь програмд урьдчилан тохируулсан хэмжээгээр гарч ирнэ. Жишээ нь 58мм -н нарийн принтерээр хэвлэнэ гэж тохируулсан бол 58мм -н өргөнтэй баримт гарна (Энэ тохиргоог өөрчлөхийг хүсвэл манай ажилтанд хандана уу). Харин үүнээс өөр хэмжээгээр, жишээ нь А4 -р баримт гаргахыг хүсвэл "Барим хэвлэх: Цаасны хэмжээ сонгох" коммандыг сонгоно.

## Борлуулалт засах

I	50РЛУУЛАЛТ	_1										
I	Ажлын хэсэг	Бараагаар хайх, За,	дгай Нэгтгэл	л: Хугацаагаар	Нэгтгэл	л: Харилцагча	аар	Нэгтгэл: Бараа	агаар	Банк ПОС і	гүйлгээ Энг	ийн жорын тайл
	🛉 📝 Sacax	< 💥 Шүүлти	<b>йн огноо:</b> 202	24-08-21 🔻	2024-08	-21 🔻 Э	мийн	сан 🔻	🍸 Шү	yx 🍸	(Харилцагч )	<b>T</b>
Γ								Д	үн			Т
	Баримтын дугаар	2 Огноо	Хаанаас	Хаанаас Харилцагч То				Төлөх дүн	Нийт төлсөн		Бэлнээр	Картаар
٩												
	000-334532	2024-08-21 16:59	Эмийн сан			1	1	20,000.00		20,000.00	20,000.0	0.00
•	000-334531	2024-08-21 16:56	Эмийн сан		Bacay		5			4,900.00	24,900.0	0.00
	000-334530	2024-08-21 16:54	Эмийн сан		Verro	·	$\leq$	3		8,000.00	68,000.0	0.00
	000-334528	2024-08-21 16:37	Эмийн сан	· · · · ·		x				6,000.00	6,000.0	0.00
	000-334527	2024-08-21 16:36	Эмийн сан	-	Бари	мт хэвлэх				2,850.00	112,850.0	0.00
	000-334519	2024-08-21 16:13	Эмийн сан		Нэхэ	мжлэх хэвлэ	<b>x:</b> A4	4		8,000.00	48,000.0	0.00

"ЦЭС -> Борлуулалт" модульруу орж "Борлуулалт" цонхыг нээнэ.

- 1) Ажлын хэсэг дэх борлуулалтын хүснэгтээс засах борлуулалтаа хайж гаргаж ирнэ. Хэрхэн хайх тухай өмнөх гарчгуудаас харна уу.
- Засах борлуулалтаа сонгож байгаад (сонгох гэдэг нь хулганаар дээр нь дарахыг хэлнэ) дээр нь хулганы баруун товчийг дараад Засах коммандыг сонгоно. Эсвэл хүснэгтийн дээр байгаа Засах товчийг дарна. Борлуулалт засах цонх нээгдэнэ.

Борлуулалт заса	х							- 4			- 🗆	×
Хаанаас	: Эмийн сан	- ··· X	Харі	илцагч:			-		• ··· x	Баримт №:	000-334531	
Гүйлгээний огноо	2024-08-21	16:56 🔻	Тэм	дэглэл:					~ 💾 и	Баримт огноо:	2024-08-21	•
			3						-	Захиалга:		
Гүйлгээний мөрү	үд Төлбөр	төлсөн байдал	эмд	н жор	И-Жо	р Устгагдо	ан мөрүүд		5			
🛉 Шинэ 🛛 🗹	3acax 🛛 💢 🛛	Устгах 🙆	_	-2								X
							Үнэ, тоо хэм	жээ			Өртөг	
Дотоод код	Баркод	Барааны н	эр	Too.	x	Нэгж үнэ	Хямдрал	Зарсан үнэ	Нийт үнэ: зарсан * тоо	Нэгж өртөг	Нийт өртөг	Зөрүү: Н үнэ - өр
9												
• 4031571052	403157105	Докси Денк ша	хм 1		14	1,000.00	0.00	1,000.00	14,000.00	4,300.00	60,200.00	-46,2
8994841000	899484100	Трогил 500мг N	l⁰10		14	350.00	0.00	350.00	4,900.00	0.00	0.00	4,9
1252	010880652	Дифлү 150мг N	94		2	3,000.00	0.00	3,000.00	6,000.00	1.00	2.00	5,9
						<u>1</u>						

#### Борлуулалт засах цонх дээр ажиллах:

- 1) Зарсан эм бараанууд хүснэгтээр харагдаж байна. Эндээс дараах үйлдлүүд боломжтой:
  - а. Эм барааны тоо хэмжээ, зарсан үнэ, хямдрал засаж болно. Үүний тулд, засах барааны нэр дээр хулганаар хоёр дарж "Гүйлгээний мөр засах" цонх нээж байгаад шаардлагатай засварыг хийгээд хадгална.
  - b. Эм барааг устгаж болно. Устгах барааны нэр дээр дарж сонгож байгаад хүснэгтийн дээр байгаа Устгах товчийг дарах эсвэл хулганы баруун товчийг дарж байгаад Устгах коммандыг сонгоно.
- 2) "Шинэ" товчийг дарж борлуулалтруу эм бараа нэмж оруулж болно. Шинэ товч дарахад "Шинэ гүйлгээний мөр бүртгэх" цонх нээгдэх ба, оруулах бараагаа нэрээр нь эсвэл баркод оруулж

сонгоод, зарсан тоо хэмжээг оруулна. Хүсвэл зарсан үнэ, хямдралын утгыг өөрчилж болно. Тэгээд Хадгалах товч дарснаар борлуулалтруу эм бараа шинээр нэмэгдэж орно.

- 3) Гүйлгээний огноо -г зөвхөн админ эрхтэй ажилтан засах боломжтой.
- 4) Харилцагч -г зээлээр борлуулалт хийсэн үед л сонгоно. Бусад үед заавал харилцагч сонгох албагүй. Бусад сонговол нэмэлт мэдээлэл болж л явна.
- 5) Тэмдэглэл дээр та өөрийн хүссэнээр юу ч бичиж болно. Гэхдээ Зээлээр борлуулалт хийсэн бол зээл авсан хүн маань хэзээ төлөх, хэдийд төлсөн гэх мэт мэдээллийг ихэвчлэн бичдэг. Бусад талбараас ялгаатай нь, Тэмдэглэлийг түүний яг ард байгаа шар өнгийн жижиг хадгалах товчоор хадгалж болдог. Өөрөөр хэлбэл тэмдэглэл хадгалахын тулд борлуулалтын доор байгаа нийт борлуулалтыг хадгалдаг Хадгалах товчийг дарах албагүй байдаг. Ингэснээр хаалт хийсэн болон Тооллогоос урагшаа орж хаагдсан, засах боломжгүй борлуулалтын тэмдэглэлийг дангаар засах боломж үүсдэг. Энэ онцлогийг хүмүүс зээлээ төлсөн тухай мэдээллийг хадгалахад голдуу ашигладаг.

Борлуулалт засах үед тухайн борлуулалтын ИБаримтыг засах хүсэлтийг програм татварруу илгээдэг. Гэхдээ дараах нөхцөлүүдэд татвар хүсэлтийг хүлээн авч ибаримтыг өөрчлөнө. Үүнд:

- Иргэнээр ибаримт гаргасан байх. Хэрэв байгууллагаар баримт гаргасан бол програмаас засах боломжгүй. Заавал Ebarimt.mn дээр засвар хийх ба хэрхэн хийх зааврыг татвараас авна.
- Иргэн ибаримтаа уншуулаагүй байх. Худалдан авагч ибаримтаа уншуулаагүй үед л програмаас ибаримт засагдана.
- Сар дотроо засах.
- Орион програм нь ИБаримттай холбогдсон байх. Борлуулалт засаж буй орион програм нь ибаримттай холбогдоогүй бол мэдээж татварруу засах хүсэлт явахгүй. Хэрэв танайх олон компьютерт орион програм суулгаж зэрэг ашигладаг бөгөөд, таны програм ибаримттай холбогдсон эсэхийг мэдэхгүй байгаа бол, ЦЭС -рүү ороод "Татвартай өгөгдөл солилцох" комманд идэвхитэй байгаа эсэхийг хараарай, идэвхитэй бол ибаримт холбосон гэсэн үг. Идэвхигүй бол ибаримт холбосон орионтой компьютер дээрээ засвараа хийнэ. Хэрэв өөрийн орионыг ибаримттай холбуулья гэвэл манай ажилтанд хандаарай.
- ИБаримтад засвар орвол иргэний авч явсан ибаримт хүчингүй болно. Учир нь татвар дээр ибаримт засахдаа, эхлээд хуучин баримтыг устгаад шинэ гэхдээ сугалаагүй баримт үүсгэдэг. Тиймээс иргэнд байгаа хуучин ибаримт хүчингүй болох ба иргэн уншуулах үед ААН илгээгүй төлөвт орчихдог. Тиймээс борлуулалт засахдаа энэ эрсдлийг бодолцоорой.

#### Борлуулалтын төлбөрийн мэдээлэл засах:

Борлуулалт засах						_ □	×
Хаанаас: Эми	йн сан 🚽 \cdots 🗙	Харилцагч:		•	х Баримт №:	000-334531	
Гүйлгээний огноо: 2024	4-08-22 15:46 🔹	Тэмдэглэл:		*	И-Баримт огноо:	2024-08-21	•
		0		T	Захиалга:		
Гүйлгээний мөрүүд	Гөлбөр төлсөн байдал	ЭМД +н жор И-Ж	Кор Устгагдсан мөрүүд				
Нийт дүн:	24,9	00.00 -	Эцсийн хэрэглэгчи	йн EBarimt руу нэвтрэх код:			
Картын	дугаар:	- x	7 Тэмдэглэл 2:		<u>ـ</u>	3	
Хямдрал	:	0.00 -	/-		Ψ	<u> </u>	
Хөнгөлө.	лт:	0.00 🔻 🕺	0.00 ?	Байгууллага	ар НӨАТ гаргах бол:		_
Урьдчил	таа:	0.00 🔻		Регистр:	<u> </u>		
Авах дүн:	24	4,900 🔻		Нэр:	$\overline{\mathbf{v}}$		.
Бэлнээ	p:	24,900.00 -	.1			^"	•
Картаар		0 🔻			QPay төлбөр	авсан данс:	
Шилжүүл	лгээр:	0 🔻				<b></b>	
Зээлээр:		0 🔻					
Нийт авсан:	24	4,900 🔻				.6	
Хариулт:		0 -	НӨАТУС ДДТД:	07100084039700117242306211	0001085	/°	
🖌 Батлах [Н	100por 1 5			æ	Хэвлэх 🔻 🖵 Хадга	лах 💽 Гар	ax

- 0) "Төлбөр төлсөн байдал" хуудасруу орно.
- 1) Бэлнээр, Картаар, Шилжүүлгээр (банкны дансруу шилжүүлсэн буюу мобайлдсан төлбөр), Зээлээр гэсэн төлбөрийн хэлбэрүүд бий. Хэрэв зарсан барааны тоо хэмжээ, зарсан үнэ зэргийг зассан бол Авах дүн хөдөлсөн байгаа. Тиймээс түүнд тааруулж төлсөн дүн (Төлсөн дүн гэдэг нь Бэлнээр, Картаар, Шилжүүлгээр, Зээлээр дүнгүүдийн нийлбэр буюу худалдан авагчийн төлсөн мөнгийг хэлж байгаа юм) -г засах ёстой болно. Жишээ нь Картаар төлсөн бол авах дүнгийн дагуу Картаар дүнгээ ижил болгож өөрчлөх ёстой. Бэлнээрээс бусад хэлбэрээр төлбөр хийсэн бол төлсөн дүн нь авах дүнтэйгээ яг таарч байх ёстой. Мөн нэг борлуулалтыг нэгээс олон хэлбэрээр хувааж төлсөн байж болно. Жишээ нь, бэлнээр 10000, шилжүүлгээр 5000, зээлээр үлдсэнг гэх мэтээр төлсөн бол харгалзах талбаруудад тохирох дүнгүүдийг оруулна.
- 2) Нийт борлуулалтын дүнгээс хөнгөлөлт хасаж болно. Үүний тулд 2-р заасан талбарт хөнгөлсөн хувийг бичих эсвэл түүний өмнөх Хөнгөлөлт талбарт хөнгөлсөн үнийн дүнг бичнэ.
- 3) Хэрэв тухайн борлуулалтын ИБаримтыг Байгууллагаар гаргах бол уг 3 -р заасан талбарт байгууллагын регистрийг оруулна. Гэхдээ нэгэнт хувь хүнээр ибаримт гаргасан бол түүнийг байгууллагаар болгож өөрчлөх боломжгүй. Хэрэв байгууллагаар ибаримт гаргах гэж байгаад санаандгүй хувь хүнээр гаргасан бол борлуулалтаа устгаад дахин шивэхээс өөр аргагүй. Устгах тухай дэлгэрэнгүй зааврыг дараагийн гарчгуудаас хараарай.
- 4) Хэрэв танайх орион програмаа QPay -тэй холбосон бөгөөд, тухайн борлуулалтын төлбөрийг QPay -р төлсөн бол энэхүү 4 -р заасан талбарт төлбөр хүлээн авсан танай дансны дугаар харагдана. Арын "..." товчийг дарж qpay төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.
- 5) "Борлуулалтын төлөв" харагдаж байна. Зурагт Ноорог гэж харагдаж байна. Орион програм дотор зөвхөн борлуулалт л Ноорог болон Батлагдсан төлвүүдэд ижил буюу аль ч тохиолдолд үлдэгдлээс хасагдаж тайланд нөлөөлж байдаг. Аа харин бусад бүх гүйлгээ (татан авалт, зарлага, тооллого г.м) батлагдаж байж л үлдэгдэлд нөлөөлж тайланд орж ирдэг ба ноорог байхдаа юунд ч нөлөөгүй байдаг. Тиймээс борлуулалтыг заавал батлах албагүй юм.
- 6) "Хадгалах" товч дарснаар тухайн борлуулалтад хийсэн бүх өөрчлөлтийг цааш баазруу хадгалж борлуулалт засах үйлдэл дуусч байгаа юм.

# Борлуулалт буцаах буюу буцаалт хийх

Борлуулалт буцаах үйлдлийг хоёр аргаар хийж болно. Энд бид илүү хялбар арга буюу Борлуулалт устгаж буцаалт хийх үйлдлийг тайлбарлана. Нөгөө арга нь "Борлуулалтын буцаалт" модулиар буцаах бөгөөд тэр тухай гарын авлагын "Борлуулалтын буцаалт модуль" сэдвээс уншиж болно.

Эмийн сан, дэлгүүрт борлуулалтаа дөнгөж шивээд, ибаримт гаргасан даруйд худалдан авагч маань газар дээрээ буцаах тохиолдол түгээмэл байдаг. Ийм үед тухайн борлуулалтаа устгасан нь амар байдаг.

Борлуулалт устгах үед татварруу ибаримт буцаах хүсэлтийг програм автоматаар явуулдаг. Уг буцаах хүсэлтийг татвар зөвшөөрч буцаалт хийхийн тулд дараах нөхцлүүд хангагдсан байх ёстой. Үүнд:

- Иргэнээр ибаримт гаргасан байх. Хэрэв байгууллагаар баримт гаргасан бол програмаас буцаах боломжгүй, заавал ebarimt.mn -рүү тухайн эмийн сан, дэлгүүрийн эрх бүхий ажилтан нэвтэрч орж буцаана. Үүнийг хэрхэн хийх тухай зааврыг татвараас авна.
- Иргэн ибаримтаа уншуулаагүй байх. Худалдан авагч газар дээрээ буцаасан буюу хэвлэсэн ибаримтыг авахгүйгээр буцаасан үед иргэн баримтаа уншуулаагүй нь тодорхой тул борлуулалтыг устгахдаа санаа зоволтгүй, ибаримт буцаагдана. Харин иргэн ибаримтаа авж яваад, хэсэг хугацааны дараа эргэж ирээд буцааж байгаа бол баримтаа уншуулсан байх магадлалтай. Ийм үед борлуулалт устгасан ч ибаримт буцахгүй байж болно. Мөн иргэн ибаримтаа уншуулсан эсэхийг орион програмаас эсвэл ebarimt.mn -с мэдэх арга байхгүйг анхаарна уу. Тиймээс ийм үед буцаалт хийх эсэхээ бодолцох хэрэгтэй.
- Сар дотроо буцаах. Яг борлуулалт хийсэн тэр өдөртөө буцаах албагүй, сар дотроо байхад болно.
- Орион програм нь ИБаримттай холбогдсон байх. Борлуулалт устгах үйлдэл хийж буй орион програм нь ибаримттай холбогдоогүй бол мэдээж татвараас буцаалт хийгдэхгүй. Хэрэв танайх олон компьютерт орион програм суулгаж зэрэг ашигладаг бөгөөд, таны програм ибаримттай холбогдсон эсэхийг мэдэхгүй байгаа бол, ЦЭС -рүү ороод "Татвартай өгөгдөл солилцох" комманд идэвхитэй байгаа эсэхийг хараарай, идэвхитэй бол ибаримт холбосон гэсэн үг бөгөөд борлуулалт устгахад ибаримт буцаах хүсэлт явна гэсэн үг юм. Идэвхигүй бол ибаримт холбосон орионтой компьютер дээрээ очиж өөрийн эрхээр нэвтэрч ороод борлуулалтаа устгаарай. Хэрэв өөрийн орионыг ибаримттай холбуулья гэвэл манай ажилтанд хандаарай.

Хүмүүс борлуулалтыг тэр даруй устгахгүй бол ибаримт нь илгээгдээд татвараас буцаах аргагүй болно гэсэн буруу ойлголттой байх нь бий. Ингэж айлтгүй бөгөөд хэрэв ибаримт болон суулгуулсан орион нь дээрхи нөхцлүүдийг хангасан бол борлуулалтыг сар дотроо багтаж устгахад болно, заавал тэр өдрөө байх албаггүй.

Заримдаа та буцаалт хиймээр байгаа ч борлуулалтаа устгамааргүй байж болно. Ихэвчлэн, тэр борлуулалт нь хэд хоногийн өмнөх бөгөөд, жор баригчтайгаа тэр өдрийн тооцоог нийлчихсэн байх үед ингэж борлуулалтаа устгахыг хүсэхгүй байх нь мэдээж. Эсвэл тэр борлуулалт нь хаалтаас эсвэл тооллогоос урагш орчихсон, угаасаа устгах боломжгүй болчихсон байж болно. Ийм үеүүдэд "Борлуулалтын буцаалт" модулийг ашиглан буцаалт хийнэ. Гарын авлагын "Борлуулалтын буцаалт модуль" сэдвээс уншиж болно.

Одоо харин буцаалт хийхийн тулд борлуулалтаа яаж устгах тухай дараагийн гарчгаас харна уу.

## Борлуулалт устгах

	<u> </u>	1 55		<u>, , , , , , , , , , , , , , , , , , , </u>	,,	•					
E	ОРЛУУЛАЛТ	1									
	Ажлын хэсэг	Бараагаар хайх, За	дгай Нэгтгэл: Ху	гацаагаар Нэгтгэ	эл: Харилцагчаа	ар Нэгтгэл: Бар	аагаар Банк ПОС	С гүйлгээ Энги	йн жорын тайла	н	
•	🛉 📝 Засах	💢 Шүүлти	<b>йн огноо:</b> 2024-08	3-21 🔻 2024-08	3-24 🔻 Эм	ийн сан 🔻 🔻	🍸 Шүүх 🛛 🍸	[Харилцагч х.	•	👔 🍦 Өд	рийн
		1					Дүн		Te	лөлтийн задарг	гаа
	Баримтын дугаар	Огноо	Хаанаас	Харилцагч	Тоо.ш	Төлөх дүн	Нийт төлсөн	Бэлнээр	Картаар	Шилжүүлгээр	З
٩											
	000-334532	2024-08-21 16:59	Эмийн сан		1	20,000.0	0 20,000.00	20,000.00	2 0.00	0.00	
Þ	000-334531	2024-08-21 16:56	Эмийн сан		30	24,900.0	0	24.000.00	0.00	٦.00	
	000-334530	2024-08-21 16:54	Эмийн сан		39	68,000.0	0 Jacas		-	.00	
	000-334528	2024-08-21 16:37	Эмийн сан		1	6,000.0	О Устга	x		.00	
	000-334527	2024-08-21 16:36	Эмийн сан		155	112,850.0	о 🌐 Бари	мт хэвлэх		.00	

"ЦЭС -> Борлуулалт" модульруу орж "Борлуулалт" цонхыг нээнэ.

- 1) Ажлын хэсгийн борлуулалтын хүснэгт дотроос устгах борлуулалтаа хайж олно. Хэрхэн хайх тухай "Борлуулалт хайх" гарчгаас дэлгэрэнгүй уншиж болно.
- 2) Устгах борлуулалт дээрээ хулганы баруун товчийг дараад Устгах коммандыг сонгоно.

Борлуулалт устгах үед тухайн борлуулалтын ибаримтыг буцаах хүсэлт татварруу илгээгддэг бөгөөд энэ тухай дэлгэрэнгүйг өмнөх "Борлуулалт буцаах буюу буцаалт хийх" гарчгаас дэлгэрэнгүй уншиж болно.

## Устгасан борлуулалт сэргээх

E	50РЛУУЛАЛТ										-	- 0	×
Г	Ажлын хэсэг	Бараага <u>ар хайх,</u> За	дгай Нэгтгэл: Хуг	ацаагаар Нэгтгэ	л: Харилцагчаа	р Нэгтгэл: Бараа	гаар Банк ПОС г	үйагээ. Энги	йн жорын тайла	н			
	3acax	🙆 Сэргээх	Шүүлтийн огноо:	2024-08-01 🔻	2024-08-25	<ul> <li>Эмийн сан</li> </ul>	т ү Шүүх	🛛 🏹 🗍 [Хар	илцагч х 🔻	X	👜 Өдрийн нэ	эгтгэл 💾	5
		$\sim$				Дү	м о	$\sim$	Тө	лөлтийн задарг	aa		
	Баримтын дугаар	Огноо	Хаанаас	Харилцагч	Тоо.ш	Төлөх дүн	Нийт төлсөн	Бэлнээр	Картаар	Шилжүүлгээр	Зээлээр	QPay	)
٩	•												<b>^</b>
•	000-334387	2024-08-21 07:57	Эмийн сан		59	72,290.00	28,645.00	28,645.00	0.00	0.00	0.00		
	000-334386	2024-08-21 07:40	Эмийн сан		59	72,290.00	28,645.00	28,645.00	0.00	0.00	0.00		
	000-334385	2024-08-21 07:39	Эмийн сан		59	72,290.00	28,645.00	28,645.00	0.00	0.00	0.00		

- 1) Ажлын хэсгээс борлуулалт сэргээнэ.
- 2) Шүүх товчны арын 2-р заасан "Устгасанг харах" товчийг дарахад устгасан борлуулалтууд гарч ирнэ.
  - а. Шүүлтийн огноог оруулаад Шүүх дарахад тэр хугацааны хоорондох устгасан борлуулалтууд гарч ирнэ.
- Сэргээх борлуулалт дээрээ хулганаар дарж сонгож байгаад, дээр нь байгаа 3 -р заасан "Сэргээх" товчийг дарж сэргээнэ.
  - a. Тухайн борлуулалтыг анх устгах үед ибаримт нь буцаагдсан бол борлуулалтыг сэргээх үед ибаримт буцаж сэргэхгүй шүү.

# Борлуулалтын өөрчлөлтийн түүх харах

Орион програм дахь өөрчлөлтийн түүх нь хэн гэж хэрэглэгч хэзээ засвар өөрчлөлт оруулсныг гаргахаас гадна бүртгэл ямар байхад ямар болгож өөрчилснийг дэлгэрэнгүй харуулдаг. Энэ нь ихэнх програмд байдагггүй манай давуу тал юм.

Б	ОРЛУУЛАЛТ												
Ľ	Ажлын хэсэг	Бараагаар хайх, За	дгай Нэгтгэл: Хүг <b>ійн огноо:</b> 2024-08	-01 <b>т</b> 2024-08	л: Харилцагчаа -25 🔻 Эми	р Нэгтгэл: Бараа ійн сан 🔻	агаар     Түүшүүү	Банк ( х	10С гүйлгээ 7 [Харил	Энгий цагч х	ін жорын тайл . ▼	ан	🚔 Өдри
						Д	үн				Т	өлөлтийн задар	гаа
	Баримтын дугаар	Огноо	2 <sub>Хаанаас</sub>	Харилцагч	Тоо.ш	Төлөх дүн	Нийт	төлсө	н Бэлн Засах	133D	Картаар	Шилжуулгээр	Зээлэ:
٩								×	Устгах				
	000-334532	2024-08-21 16:59	Эмийн сан		1	20,000.00		-	Баримт хэ	влэх			
×	000-334531	2024-08-21 16:56	Эмийн сан		23	22,450.00		Å.	Нэхэмжлэ	х хэвлэ	x: A4		
	000-334530	2024-08-21 16:54	Эмийн сан		39	68,000.00		4	Нэхэмжлэ	х хэвлэ	x: A5		
	000-334528	2024-08-21 16:37	Эмийн сан		1	6,000.00			Баримт хэ	влэх: Ц	аасны хэмжэ	э сонгох	
	000-334527	2024-08-21 16:36	Эмийн сан		155	112,850.00	1						_
	000-334519	2024-08-21 16:13	Эмийн сан		120	48,000.00			Кассын ор	логын	баримт хэвлэ	эх	
	000-334518	2024-08-21 16:12	Эмийн сан	<b>`</b>	120	478,500.00	1		Банкны ка	ртын ба	аримт хэвлэх		
	1,802 ш				62,298	05,438,400.00	40,20		JSON текст	г файл ү	үүсгэх (EBarin	nt)	
4				>					JSON TEKC	г файл у	wcrax (NDaat	igal)	
						YH	э, тор хэм		Өөрчлөлт	ийн түү	х харах	>	Өртөг

- 1) Ажлын хэсгээс өөрчлөлтийн түүх харна.
- Шүүлтийн огноо болон хүснэгтийн шүүлтийн мөрийг ашиглан өөрчлөлтийн түүхийг нь харах борлуулалтаа хайж хүснэгт дээр гаргаж ирнэ. Хэрхэн хайж шүүх тухай дэлгэрэнгүйг "Борлуулалт хайх" гарчгаас дэлгэрэнгүй харж болно.
- Борлуулалт дээрээ хулганы баруун товчийг дараад "Өөрчлөлтийн түүх харах" коммандыг сонгож "Барааны борлуулалтын өөрчлөлтийн түүх" цонхыг нээнэ. Уг цонх дээр өөрчлөлтийг хэрхэн харахыг доор тайлбарлав:

Одоо доорхи хоёр зургийг харьцуулан, борлуулсан эм бараанд ямар засвар оруулсныг харцгаая:

#### Зураг №1:

Барааны борлуулалтын өөрч	алөлтийн түүх									- 0	×
Гүйлгээний мөрүүд дэх өөрчл	элтүүд Гүйлгээний т	голгоі	й мэдээллийн өөрчлө.	лтүүд							
Өөрчлөлт орсон огнооны жаго	аалт:		Ангилал	Дотоод код	Баркод	Барааны нэр	Нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Нийт >
Өөрчлөлт орсон огноо	Өөрчлөлт хийсэн	9									
	хэрэглэгч	•	Зайлшгүй шаар	4031571052163	4031571052163	Докси Денк шахм 100мг	ш	14.0000	1,000.00	14,000.00	
2024-08-21 17:11:44:633	admin		Зайлшгүй шаар	8994841000201	8994841000201	Трогил 500мг №10	ш 🔇	14.0000	350.00	4,900.00	
2024-08-21 17:11:44:703	admin		Бусад	1252	0108806529001	Дифлү 150мг №4	ш	2.0000	3,000.00	6,000.00	
2024-08-21 17:11:44:810	admin						21				
2024-08-25 11:56:39:200	sysadmin										
1				3 ш				30.0000		24,900.00	0.00
	1		$\subset$								F
	<ul> <li>Өөрчлөлтийг ялгах</li> <li>Өөрчлөгдсөн нүд</li> <li>Эевхөн өөрчлөгдсөн мөр харах</li> <li>Бүх мөрийг харах</li> <li>Энэ өөрчлөлтөөр устгасан мөрүүд:</li> </ul>										
4ш	Ангилал         Дотоод код         Баркод         Барааны нэр         Нэгж         Тоо хэмжээ         Нэгж үнэ         Нийт үнэ										
•											

- Зүүн талын хүснэгт дээр хэзээ хэзээ өөрчлөлт орсныг огноогоор нь жагсааж харуулсан байна. "Өөрчлөлт орсон огноо" талбараас огноо сонгож дарснаар баруун талын хүснэгт дээр тухайн үед борлуулалт ямар байсан нь гарч ирнэ. Мөн өмнөх огнооны үеээс тухайн сонгосон огнооны үед юу өөрчлөгдсөн нь улаанаар тодорч харагдана. Зурагт, жишээ болгож 8 сарын 21 -ны 17 цагийг сонгож баруун талын хүснэгт дээр энэ үед борлуулалт ямар байсныг харуулсан байна.
- 8 сарын 21 -ны 17 цагийн үед Трогил 500мг эмээс зарсан тоо хэмжээ нь 14 байсан байна. Одоо зураг №2 -г харья:

Барааны борлуулалтын өөр	члөлтийн	түүх									- 0	×
Гүйлгээний мөрүүд дэх өөрчл	өлтүүд	Гүйлгээний	толго	й мэдээллийн өөрчлө	лтүүд							
Өөрчлөлт орсон огнооны жаг	саалт:			Ангилал	Дотоод код	Баркод	Барааны нэр	Нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Нийт :
Өөрчлөлт орсон огноо	Өөрчлө.	лт хийсэн		٩								
	хэрэ	ялягч		<ul> <li>Зайлшгүй шаар</li> </ul>	4031571052163	4031571052163	Докси Денк шахм 100мг	ш	14,0000	1,000.00	14,000.00	
2024-08-21 17:11:44:633	admin			Зайлшгүй шаар	8994841000201	8994841000201	Трогил 500мг №10	ш 🤇	7.0000	350.00	2,450.00	
2024-08-21 17:11:44:703	admin			Бусад	1252	0108806529001	Дифлү 150мг №4	ш	2.0000	3,000.00	6,000.00	
2024-08-21 17:11:44:810	admin						2					
2024-08-25 11:56:39:200	sysadmir				_	~		-				
	<b>7</b>				3 ш				23.0000		22,450.00	0.00
1/				4 🤇								÷
				🗹 Өөрчлөлтийг ялга Энэ өөрчлөлтөөр у	ах Өөрчлөг стгасан мөрүүд:	дсөн нүд 🔘 Зөв>	ен өөрчлөгдсөн мөр харах	🖸 Бүх мөр	рийг харах			
	_			Ангилал	Дотоод код	Баркод	Барааны нэр	Нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Нийт :
4u	1		F	۰ ــــــــــــــــــــــــــــــــــــ				_				Þ

#### Зураг №2:

- Өмнөх 8 сарын 21 -ны 17 цагийн яг дараагийн өөрчлөлт орсон огноо буюу 8 сарын 25 -ны 11 цагийг сонгосон байна. Баруун талд энэ үед борлуулалт өмнөх үе буюу 8 сарын 21 -ээс юу нь өөрчлөгдсөн нь харагдаж байна.
- 8 сарын 25 -ны 11 цагийн үед Трогил 500мг эмийн зарсан тоо хэмжээ нь 7 болж өөрчлөгдсөн байгаа нь улайж харагдаж байна. Өөрөөр хэлбэл 8 сарын 21 -нд 14 байсан тоог 8 сарын 25 -нд sysadmin гэдэг хэрэглэгч 7 болгож өөрчилсөн байгаа нь харагдаж байна.

Одоо борлуулалт доторхи барааны өөрчлөлт биш, борлуулалтын төлбөр, огноо, тэмдэглэл зэрэг баримтын толгой хэсгийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг харцгаая:

E	арааны борлуулалтын Гүйлгээний мөрүүд дэх	н өөрчлөлтийн түүх өөрчлөлтүүд Сүйлгэ:	эний толгой мэдээлл	ийн өөрчлөлтүүд	>_1					-		
	Өөрчилсөн огноо	Гүйлгээний огноо	Хаанаас	Харилцагч	Бэлнээр	Картаар	Дансаар	Зээлээр	Хөнгөлөлт	НӨАТУС + ДДТД	НӨАТУС + Байгууллагы	н н.
٩			]									1
	2024-08-21 17:11:4	2024-08-21 16:56:57	Эмийн сан		24,900.00	0.00	0.00	0.00	0.00			1
	2024-08-21 17:11:4	2024-08-21 16:56:57	Эмийн сан		24,900.00	0.00	0.00	0.00	0.00	0710008403970		
	2024-08-25 11:56:5	2024-08-21 16:56:36	Эмийн сан		24,900.00	0.00	0.00	0.00	0.00	0710008403970		
	2024-08-25 11:56:5	2024-08-21 16:56:36	Эмийн сан		0.00	22,450.00	0.00	0.00	0.00	0710008403970		1
	2024-08-25 11:56:5	2024-08-21 16-56;36	Эмийн сан	5-	0.00	22,450.00	0.00	0.00	0.00	0710008403970		
		2										Т

- "Гүйлгээний толгой мэдээллийн өөрчлөлтүүд" хуудсыг сонгоно. Энд гүйлгээний толгой хэсгийн мэдээлэл буюу огноо, төлбөр, тэмдэглэл зэрэг мэдээллүүдэд орсон өөрчлөлтүүдийг өөрчилсөн огноогоор нь жагсааж харуулна.
- 2) Зураг дээрхи жишээнд, "Өөрчилсөн огноо" баганад нийт 5 удаагийн өөрчлөлт хийсэн нь харагдаж байна.
- 3) Зураг дээрхи жишээнд, 8 сарын 21 -нд Бэлнээр дүн 24,900 төгрөг байсан бол 8 сарын 25 -нд бэлнээр дүнг 0 болгоод, Картаар дүнг 24,900 болгож өөрчилсөн нь улайж харагдаж байна.

Хүснэгтийн төгсгөлд өөрчлөлт бүрийг хэн гэдэг хэрэглэгч хийсэн нь харагдана. Мөн, хэрэв борлуулалтыг устгасан бол, хүснэгтийн эхэнд "Өөрчилсөн огноо" талбарт хэзээ устгасан нь харагдах ба хүснэгтийн төгсгөлд "Хийсэн үйлдэл" багана дээр "Устгасан" гэх үйлдлийн нэр нь харагдана.

# Борлуулалт хэн хийснийг харах, борлуулалт хийсэн ажилтан/хэрэглэгчээр шүүх

БОРЛУУЛ	АЛТ									— C	י כ	×
Ажлын хэ	сэг Ба	раагаар хайх, Задга	й Нэгтгэл: Хугац	цаагаар Нэгтгэл:	Харилцагчаар Н	эгтгэл: Бараагаар	Банк ПОС гүйлгээ	Энгийн жорын т	айлан			
+ 18	3acax	💥 Шүүлтийн	огноо: 2024-08-0	1 🔻 2024-08-3	31 🔻 Эмийн сан	н 🔻 🍸 Шү	үх 🍸 [Хари	лцагч х 🔻	×E	🚔 Өдрийн нэгтгэл	8	5
	1				_							
Худалда байгуул ТТ	ан авагч ллагын "Д	Эцсийн хэрэглэгчийн код	Харилцагчийн хаяг	Холбоотой Буцаалтын дугаар	Холбоотой ЗАХИАЛГЫН КОД		Хөнгөлөлтийн карт	Өөрчилсөн огноо	Үүсгэсэн огноо	Устгасан огноо		
Ŷ						admin						<b>^</b>
					4	admin		2024-08-21 17:14	2024-08-21 17:14		-15	; U
					-	admin		2024-08-25 11:56	2024-08-21 17:11		-15	<b>i</b>
						admin		2024-08-21 17:10	2024-08-21 17:10		-16	;
						admin		2024-08-21 16:52	2024-08-21 16:52		-15	;
						admin		2024-08-21 16:50	2024-08-21 16:50	, 3	-14	+
						admin		2024-08-21 16:28	2024-08-21 16:28		-15	; <b>-</b>
4									$\leq$	>		0 F
🗙 🗹 Хайо	ж буй утг	аар эхэлсэн([Гүйлгэз	э хийсэн хэрэглэгч]	, 'admin')						L	Шүүлт хи	ийх

- 1) Ажлын хэсэгт борлуулалтыг ажилтнаар шүүнэ.
- 2) Шүүлтийн огноонд тухайн ажилтны хэднээс хэдний хоорондох борлуулалтыг харахаа оруулаад Шүүх дарна. Ихэвчлэн хүмүүс нэг сараар шүүдэг. Учир нь, зарим эмийн сан, дэлгүүрүүд ажилтандаа сарын борлуулалтын орлогоос хамаарсан бонус урамшуулал өгдөг.
- 3) Scroll bar -г хулганаар чирээд хүснэгтийн төгсгөлд очино.

4) "Гүйлгээ хийсэн хэрэглэгч" баганын эхний хоосон нүд буюу хайлтын нүдэнд ажилтныхаа орион програмд нэвтэрдэг хэрэглэгчийн нэрийг бичиж тухайн ажилтны хийсэн борлуулалтуудыг шүүж гаргаж ирнэ. Хүснэгт дээр хэрхэн шүүлт хийх тухай гарын авлагын "Хүснэгтийг бүрэн ашиглаж сурах" сэдвээс харж болно.

		Дү	/H		Te	лөлтийн задарг	aa			Хөнгөлөлт, хям	ідрал, даатгал	
	Тоо.ш	Төлөх дүн	Нийт төлсөн	Бэлнээр	Картаар	Шилжүүлгээр	Зээлээр	QPay	Хөнгөлөлт	Хямдрал	ЭМД хөнгөлөлт	Урьдчилг
												<b>^</b>
	1	20,000.00	20,000.00	20,000.00	0.00	0.00	0.00		0.00	0.00	0.00	U
	23	22,450.00	22,450.00	0.00	22,450.00	0.00	0.00		0.00	0.00	0.00	
	39	68,000.00	68,000.00	68,000.00	0.00	0.00	0.00		0.00	0.00	0.00	
	1	6,000.00	6,000.00	6,000.00	0.00	0.00	0.00	∕6	0.00	0.00	0.00	
	155	112,850.00	112,850.00	112,850.00	0.00	0.00	0.00		0.00	0.00	0.00	
	120	48,000.00	48,000.00	48,000.00	0.00	0.00	0.00		0.00	0.00	0.00	· ·
	62,224	67,427,580.00	40,197,982.00	35,848,463	4,349,519.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	27,229,598.00	0.00
		$\sim$	$\sim$		_							÷
🖊 Xa	йж буй утгаар	эхэлсэн([Гүйлгээ хи	йсэн хэрэглэгч], 'ad	min')	5							Шүүлт хийх

5) Scroll bar - аа хулганаар чирж хүснэгтийн эхлэлрүү очино.

- 6) Хүснэгтийн хөл дэх нэгтгэл дүнгүүдийг харна. Энд тухайн ажилтны хийсэн сарын борлуултын дүн харагдаж байгаа.
  - a. Борлуулалтын хүснэгтийн хөл дүнг зөвхөн админ эрхтэй хэрэглэгч хардаг, жор баригчид хардаггүй болгож нууж болно. Ийм тохиргоо хийлгэе гэвэл манай ажилтанд хандана уу.

## Өдрийн нэгтгэл хэвлэх

Б	ОРЛУУЛАЛТ										-	· 🗆	×
7	Ажлын хэсэг	Бараагаар хайх, За	дгай Нэгтгэл: Хуг	ацаагаар Нэгтг	эл: Харилцагчаа	р Нэгтгэл: Бараа	агаар Банк ПОС і	гүйлгээ Энгий	і́н жорын тайла	н	-	_	
	🛉 📝 Засах 💥 Шүүлтийн огноо: 2024-08-21 🔻 2024-08-21 🔻					ийн сан 🔻	🍸 Шүүх 🛛 🍸	[Харилцагч х	. •	X8 🤇	늵 Өдрийн нэ	гтгэл 💾	5
		1				Дı	үн		Te	лөлтийн задарг	aa		
	Баримтын дугаар	Огноо	Хаанаас	Харилцагч	Тоо.ш	Төлөх дүн	Нийт төлсөн	Бэлнээр	Картаар	2 Шилжүүлгээр	Зээлээр	QPay	)
٩													<b>^</b>
	000-334532	2024-08-21 16:59	Эмийн сан		1	20,000.00	20,000.00	20,000.00	0.00	0.00	0.00		
	000-334531	2024-08-21 16:56	Эмийн <mark>са</mark> н		23	22,450.00	22,450.00	0.00	22,450.00	0.00	0.00		
	000 004500	0004-00-04-46-54	- ·			co. 000. 00	co. 000. 00	<u></u>	0.00	0.00	0.00		

- 1) Ажлын хэсгээс өдрийн нэгтгэл хэвлэнэ.
- 2) "Өдрийн нэгтгэл" товчийг дарж "Нэгтгэл баримт хэвлэх" цонхыг нээнэ. Энд тохирох утгуудыг

Нэгтгэл баримт хэ	влэх		_		Х
Дараах ху хэвлэнэ!	гацааны хооронд хийг	дс	эн гүйлгээі	г нэгтгэ)	к
	Бүтэн өдрөөр: өдрийн	нбγ	үх гүйлгээг	ору	•
Огноо:	2024-08-21 🔹	-	2024-08-2	1	•
Салбар / Дэлгүүр :	Эмийн сан				•
Хөтөлсөн кассир :	admin				•
	Нийт борлуулалт				•
		(эв.	лэх	Буца	ax

оруулаад "Хэвлэх" товчийг дарна.

3) "Шууд хэвлэх" товчийг дарж принтерээрээ хэвлэнэ.

Хэвлэх						
Тохиргоо Харагдалт Хуудасны фоно						
₩ 80%	▼ 🔍   K 🔺 🕨   📴 ▪   🗋 ▪					
$\sim$	'					
3	Хаанаас : Эммйн сан НЭГТГЭЛ БАРИМТ Огноо : 2024/08/21 - 2024/08/21					
	Нийт тоо.х : 5,972.000					
	НИЙТ АВАХ ДҮН: 4,426,340.00					
	Хямдрал: 1,396,064.00					
	Хенгелелт: 0.00					
	Урьдчилгаа : 0.00					
	НИИТ АВСАН ДҮН : 3,030,276.00					
	Бэлнээр: 3,007,826.00					
	Картаар : 22,450.00					
	Дансаар: 0.00					
	Зээлээр : 0.00					
	QPay: 0.00					
	Kacc: admin					
	Хүлээлгэн өгсөн :					
	Хулээн авсан :					
	Шалгасан ня-бо :					

Анхаарах зүйлс:

— Өдрийн нэгтгэл хэвлэсэн бол жор баригчийн тушаасан орлого, тооцоотой тулгаад, хэрэв зөрж байвал ард нь зөрүүг нь бичиж тэмдэглэнэ. Зөрөх шалтгаан юу ч байж болно, жор баригч орлогоосоо бөөний төвийн барааны төлбөр төлсөн байж болно, бусад зардалд зарцуулсан байж болно, ийм үеүүдэд жор баригчийн тушааж буй мөн бага байх ёстой. Заримдаа жор баригч зарим борлуулалтаа шивээгүй байж болно (мартсан, амжаагүй г.м шалтгаанаар). Ийм үед жор баригчийн тушаасан орлого нэгтгэл баримт дахь дүнгээс их байх ёстой. Тулгалт дууссан бол жор баригч болон шалгасан эрхлэгч / нябо нар цаасан баримт дээрээ гарын үсгүүдээ зурж цааш хадгалах ёстой.

# Борлуулалтыг Сараар нэгтгэж харах

Б	ОРЛУУЛАЛТ								-		×
A	жлын хэсэг Ба	раагаар хайх, Зад	дгай Нэгтгэл	: Хугацаагаар	Нэгтгэл: Харилц;	агчаар Нэгтгэл:	Бараагаар	Банк ПОС гүйлгээ	Энгийн жорь	ын тайлан	
Ш	үүлтийн огнос:	2024-05-25	2024-08-2	5 🔻 Cap	baap 🔻 🍦	Шүүх	3		X	Excel -pyy r	гаргах
	Хугацааны үе	Хаанаас	Гүйлгээний тоо	2 <sup>тоо.ш</sup>	Төлөх дүн	Нийт төлсөн	Бэлнээр	Картаар	Шилжүүлгээр	Зээлээр	
۴				-							
Þ	24-05 cap	Салбар 2	155	4,394	3,674,010.00	2,194,516.00	734,500.	00 1,460,016.00	0.00	0	.00
	24-05 cap	Эмийн сан	572	20,171	22,148,495.00	13,782,178.00	9,782,147.	00 4,000,031.00	0.00	0	.00
	24-06 cap	Салбар 2	648	20,528	22,990,480.00	11,848,426.00	7,474,237.	00 4,341,289.00	32,900.00	0	.00
	24-06 cap	Эмийн сан	2,315	81,565.4359	86,789,807.01	49,957,613.00	42,852,737.	00 7,104,876.00	0.00	0	.00
	24-07 cap	Салбар 2	419	12,484	14,241,880.00	7,987,704.00	429,056.	00 6,927,118.00	631,530.00	0	.00
	24-07 cap	Эмийн сан	4 1,978	73,420	80,615,142.00	44,983,200.00	38,122,202.	00 6,860,998.00	0.00	0	.00
	24-08 cap	Салбар 2	412	14,582	15,340,095.00	8,471,508.00	338,700.	00 7,498,308.00	634,500.00	0	.00
	24-08 cap	Эмийн сан	1,802	62,298	67,438,400.00	40,202,490.00	35,848,463.	00 4,354,027.00	0.00	0	.00
	8 u	Ш	8,301 ш	289,442.4	313,238,309.01	179,427,635.00	135,582,04	42,546,663	1,298,930.00	0	.00
4											ŀ

- 1) "Нэгтгэл: Хугацаагаар" хуудасруу орно.
- 2) Шүүлтийн огноонд нэгтгэл харах хугацаагаа оруулна.
- 3) Шүүх дарж нэгтгэлээ гаргаж ирнэ.
- 4) Хэрэв олон салбартай бол салбар бүрээр нэгтгэл харагдана.
- Эндээс та танай борлуулалт ерөнхийдөө өсч байгаа эсэхээ харахад хялбар.
- Мөн банкнаас зээл авах үед, банк сүүлийн 6 сарын борлуулалтын мэдээгээ гаргаж өг гэж шаарддаг. Ийм үед энэхүү нэгтгэл тайланг 6 сараар шүүгээд, зүүн дээд буланд байгаа "Excel -рүү гаргах" товчоор excel -рүү гаргаж аваад банкинд өгч болно.